



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/228

Арвайхээр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр суманд гэрэлт гудамж байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Даваасүрэн (Аймгийн Засаг даргын дэргэдэх
Орон нутгийн өмчийн газрын Худалдан
авах ажиллагааны албаны дарга)

Нарийн бичгийн дарга: - Т.Эрдэнэсүрэн (Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон
нутгийн өмчийн газрын ажил худалдан авах
ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн)

Гишүүд: - О.Цэрэнчимэд (Аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан
бодогч)

-Г.Даваатогтох (Хувийн хэвшлийн төлөөлөл)

-Ш.Авирмэд (Бүтээлч хөгжлийн хөтөч ТББ-ын гишүүн) (зөвшилцсөнөөр)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Б.Даваасүрэн)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж архив-бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Т.Эрдэнэсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100505